



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

**Төрийн өмчит компаниудын
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүдийг үргэлжлүүлэн томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн дүгнэлтийг харгалзан хавсралтад заасан хараат бус гишүүдийг улируулан сонгосугай.

2.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хараат бус гишүүдэд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудад тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 247
дүгээр тогтоолын хавсралт



ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР УЛИРУУЛАН
СОНГОХ ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН НЭРС

Д/д	Компанийн нэр	Төрийн эзэмшлийн хувь	Улируулан сонгох хараат бус гишүүд
1	"Төрийн орон сууцны корпораци" ХХК	100	Л.Амгалан Ж.Галбадрах



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

“Төрийн орон сууцны корпораци” ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн дүгнэлт, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 05/10342 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Дамдинсүрэнгийн Алтангэрэлийг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хараат бус гишүүнд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001854

17-r huraldaan.docx

**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
НЭР ДЭВШҮҮЛЭХ ТҮР ХОРООНЫ ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Хараат бус гишүүн сонгон
шалгаруулсан тухай

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх түр хорооны дарга Д.Нямдэлгэр, гишүүн Х.Ган-Очир, Ц.Шинэхүү нар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1, 81 дүгээр зүйлийн 81.2, 81.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сонгон шалгарууллаа.

Нэр дэвшүүлэх түр хороонд дугуй бүхий нийт 6 хүний /Н.Бямбадорж, А.Чулуунбат, Д.Алтангэрэл, Б.Ууганхүү, Ё.Байгалмаа, Я.Оюунсүрэн/ баримт материал ирүүлснийг баримтын бүрдэл хангасан байдал, тавигдах шаардлага хангасан байдал, мэргэжлийн мэдээлэл, нийт оноо зэргээр тус тус хавсралтаар дүгнэлээ.

Нэр дэвшигчдээс хамгийн өндөр оноо авсан Д.Алтангэрэлийг “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн хараат бус гишүүнээр томилуулах дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлж байна.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

ГИШҮҮД:



Д.НЯМДЭЛГЭР

Х.ГАН-ОЧИР

Ц.ШИНЭХҮҮ

**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

Хуралд Нэр дэвшүүлэх түр хорооны дарга Д.Нямдэлгэр, гишүүн Х.Ган-Очир, Ц.Шинэхүү нар оролцов. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Нэр дэвшүүлэх хорооны гишүүн хараат бус гишүүн Ж.Галбадрах, Д.Амгалан нарыг 2023 оны 11 дүгээр сард томилогдсонтой холбоотойгоор үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэр гаргах болсонтой холбогдуулан түр хороо байгуулсан болно.

Хурлыг цахимаар зохион байгуулж, Нэр дэвшүүлэх түр хорооны дарга Д.Нямдэлгэр удирдаж явуулав.

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн сонгон шалгаруулах зарыг 2023 оны 04 дугаар сарын 8-ны өдрийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын сайт, Төрийн орон сууцны корпорацийн сайт болон Топ мэдээ, Дардас, 24 цаг, Ихаус, Зиндаа сонинд 5 хоногийн хугацаатай тавьж, сонирхсон нэр дэвшигчдийн материалыг “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 208 тоотод 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 12.30 цаг хүртэл хүлээн авсан. 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр нэр дэвшигчдийн битүүмжилсэн материалыг Нэр дэвшүүлэх хороо хүлээн авч, сонгон шалгаруулалтыг явуулсан болно.

ХЭЛЭЛЦСЭН нь: “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах тухай.

ТЭМДЭГЛЭСЭН нь:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчдын ирүүлсэн материалын бүрдэл, шаардлагыг хангасан байдал, ажилласан жил зэргийг нягталж Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1, 81 дүгээр зүйлийн 81.2, 81.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сонгон шалгаруулалтыг явууллаа.

Өмнө нь сонгогдсон 2 хараат бус гишүүн маань нягтлан бодогч болон эрх зүйч мэргэжилтэй тул энэ удаагийн сонгон шалгаруулах 1 хараат бус гишүүн салбарын чиглэлийн хүн байхаар сонгон шалгаруулалтыг явуулахаар тогтсон.

Сонгон шалгаруулалтад ирүүлсэн нийт 6 хүний битүүмжилсэн материалыг хүлээн авч үзүүлэлт бүрээр нягтлан шалгасан болно. Н.Бямбадорж-эрх зүйч, А.Чулуунбат-инженер эдийн засагч, Д.Алтангэрэл-философич, нийгмийн удирдлагын магистр, Б.Ууганхүү-олон улсын эдийн засгийн харилцаа, санхүүч, Ё.Байгалмаа-нябо эдийн засагч, эрх зүйч, Я.Оюунсүрэн-нягтлан бодогч, эдийн засагч, англи хэлний орчуулагч мэргэжилтэй.

Нэр дэвшигчид компанийн хараат бус гишүүнд нэрээ дэвшүүлэн холбогдох баримт материалыг бүрдүүлэн ирүүлсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо Компанийн тухай хуульд заасан хараат бус гишүүнд тавигдах шалгуурыг хангасан байдлыг дөрвөн үе шаттайгаар 0-1 оноогоор дүгнэлээ.

Эхний шатанд сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалын үнэн зөв бүрдэл, хувь хүний асуудалд хандах хандлага, нягт нямбай байдлыг, дараагийн

шатанд нэр дэвшигчийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллах явц дахь ашиг сонирхлын зөрчил, барилгын салбарын болон хууль, эрх зүй, санхүү эдийн засгийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, тухайн салбарт ажиллаж байсан туршлага, ажилласан жил зэргийг онцгойлон харгалзаж үзсэн болно.

Нэр дэвшигчдийн мэргэжил, мэргэшил, ажилласан жилийн талаарх мэдээллийг дөрөвдүгээр хавсралтаар гаргав.

3 нэр дэвшигчдийн материалын бүрдэл бүрэн хангагдсан, 3 нэр дэвшигчдийн материалын бүрдэл дутуу байсан бөгөөд мэргэжил, мэргэшил, ажилласан жил, салбарын талаар зохих мэдлэг, туршлагатай байх, компанийн засаглалын ахисан түвшин зэргийг нарийвчлан харж 1-6 дүгээр байр эзлүүлсэн болно.

1 дүгээрт: Н.Бямбадорж нь эрх зүйч мэргэжилтэй. Мэргэжлээрээ 22 жил ажилласан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 14 жил, Автотээврийн үндэсний төвд 8 жил ажилласан туршлагатай. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн даргаар ажилладаг.

2 дугаарт: А.Чулуунбат нь инженер эдийн засагч мэргэжилтэй, сантехникчийн слесарийн мэргэжлийн 4-р зэрэгтэй. Мэргэжлээрээ 33 жил ажилласан туршлагатай. Компанийн засаглал, нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн. Тэтгэвэртээ гарсан.

3 дугаарт: Д.Алтангэрэл нь философич, нийгмийн удирдлагын магистр мэргэжилтэй, эрх зүйн магистраар суралцаж байгаа. Мэргэжлээрээ 21 жил ажилласан ажлын туршлагатай. Бүгд найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсад мэргэжил дээшлүүлсэн. 2009-2013 онд ЗТБХБЯ-ны Сургалт судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албанд Удирдлага, дотоод хяналтын хэлтсийн дарга, 2016-2021 онд “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Дотоод хяналт, хуулийн албаны дарга, 2021 оноос Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын Захиргаа, хуулийн хэлтсийн даргаар ажилладаг.

4 дүгээрт: Б.Ууганхүү нь олон улсын эдийн засгийн харилцаа, санхүүч мэргэжилтэй. Мэргэжлээрээ 13 жил ажилласан туршлагатай. Төслийн гүйцэтгэлийн үр дүнтэй худалдан авалт, төслийн загварчлал, мониторинг, хөрөнгө оруулалтаар мэргэшсэн. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн тээвэр логистикийн газрын даргаар ажиллаж байгаад 2023 оны 08 сард өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдсөн.

5 дугаарт: Ё.Байгалмаа нь нягтлан бодогч, эдийн засагч, эрх зүйч мэргэжилтэй, мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй. Төрийн албанд 36 жил ажилласан туршлагатай. Шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн эрхийн гэрчилгээтэй. Хөвсгөл аймгийн дахь шүүхийн тамгын газарт Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байгаад 2023 оны 09 сард ажлаасаа чөлөөлөгдсөн.

6 дугаарт: Я.Оюунсүрэн-нягтлан бодогч, эдийн засагч, англи хэлний орчуулагч мэргэжилтэй. Мэргэжлээрээ 16 жил ажилласан туршлагатай. Мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламж бүхий аудиторын эрхтэй. “Цемент шохой” ТӨХК-нд ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитор оор ажилладаг.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшсэн Д.Алтангэрэл нь 2009 оноос өнөөдрийг хүртэл барилга, орон сууц нийтийн аж ахуйн салбарт ажиллаж барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, нийтлэг мөрдөх норм, нормативын баримт бичиг, журам, стандарт мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөгөөгөөр хангах, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллаж байсан туршлага нь нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, шалгуурыг хангасан тул Компанийн тухай хуулийн 81.5.3 дахь заалтын дагуу тус Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгож батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар тогтов.

Хавсралт: 4 хуудас /Баримт, материалын бүрдэлт Хавсралт 1, Хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур Хавсралт 2, мэргэжлийн судалгаа Хавсралт 3, шалгаруулалтад тэнцсэн эсэх Хавсралт 4, Хурлын тэмдэглэл/

НЭР ДЭВШҮҮЛЭХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА



Д.НЯМДЭЛГЭР

ГИШҮҮД:



Х.ГАН-ОЧИР

Ц.ШИНЭХҮҮ

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн материалын бүрдэлтийн байдал

Д/Д	Нэр дэвшигчид	Материал бүрдэлт (0-1 гэсэн оноогоор дүгнэх)										
		Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт	Анкет (төрийн албан хаагчийн анкетийг бүрэн бөглөх, 4 x 6 хэмжээтэй цээж зураг заавал наасан байх)	Ажил байдлын тодорхойлолт	Нийгмийн даатгалын лавлагаа /e-mongolia-с татан авах/	Боловсролын түвшнийг тодорхойлсон баримт бичиг	Иргэний үнэмлэхийн хуулбар	Компанийн засаглалын гэрчилгээний хуулбар	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт	Банк, санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа	Нийт оноо	Материалын бүрдэлт хангасан эсэх /Тийм, үгүй/
1	Н.Бямбадорж	1	1	1	1	1	1	1	1	1	9	Тийм
2	А.Чулуунбат	1	1	1	0	1	1	1	1	0	7	Үгүй
3	Д.Алтангэрэл	1	1	1	1	1	1	1	1	1	9	Тийм
4	Б.Ууганхүү	1	1	1	1	1	1	1	1	0	8	Үгүй
5	Ё.Байгалмаа	1	1	1	1	1	1	0	1	0	7	Үгүй
6	Я.Оюунсүрэн	1	1	1	1	1	1	1	1	1	9	Тийм

НЭР ДЭВШҮҮЛЭХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Гишүүд:

..... /Д.НЯМДЭЛГЭР/
 /Х.ГАН-ОЧИР/
 /Ц.ШИНЭХҮҮ/




"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд тавигдах шаардлага хангасан байдал

Огноо: 2024.04.16

Д/д	Нэр дэвшигчид	Тавигдах шаардлага (0-1 гэсэн оноогоор дүгнэх)							
		Тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай байх.	Тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхол үүсгэхгүй байх.	Нэр дэвшигч нь өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх.	Нэр дэвшигч өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй байх.	Төрийн үйлчилгээнийхээс өөр төрийн алба хашдаггүй байх.	Тухайн компанитай бизнесийн аливаа холбоогүй байх.	НИЙТ ОНОО	Шаардлага хангасан эсэх /Тийм, үгүй/
1	Н.Бямбадорж	1	1	1	1	1	1	6	Тийм
2	А.Чулуунбат	1	1	1	1	1	1	6	Тийм
3	Д.Алтангэрэл	1	1	1	1	1	1	6	Тийм
4	Б.Ууганхүү	1	1	1	1	1	1	6	Тийм
5	Ё.Байгалмаа	1	1	1	1	1	1	6	Тийм
6	Я.Оюунсүрэн	1	1	1	1	1	1	6	Тийм

НЭР ДЭВШҮҮЛЭХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Гишүүд:


 /Д.НЯМДЭЛГЭР/

 /Х.ГАН-ОЧИР/

 /Ц.ШИНЭХҮҮ/

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтад
нэр дэвшигчдийн мэргэжил

д/д	Нэр дэвшигчид	Мэргэжил	Сургууль төгссөн огноо	Мэргэжлээрээ ажилласан жил
1	Н.Бямбадорж	эрх зүйч	2003.01.27.	22
2	А.Чулуунбат	инженер эдийн засагч	2007.07.03.	33
3	Д.Алтангэрэл	философич, нийгмийн удирдлагын магистр	2003.06.10. 2006.05.29	21
4	Б.Ууганхүү	олон улсын эдийн засгийн харилцаа, санхүүч	2010.06.03. 2021.05.15.	13
5	Ё.Байгалмаа	нябо эдийн засагч, эрх зүйч	2004.11.15. 2015.02.27.	36
6	Я.Оюунсүрэн	нягтлан бодогч, эдийн засагч, англи хэлний орчуулагч	1999.06.04. 2010.02.05. 2012	16

НЭР ДЭВШҮҮЛЭХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Гишүүд:

..... /Д.НЯМДЭЛГЭР/
 /Х.ГАН-ОЧИР/
 /Ц.ШИНЭХҮҮ/

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалт
ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх түр хороо




Хараат бус гишүүнийг сонгон шалгаруулсан байдал

Огноо: 2024.04.16

д/д	Нэр дэвшигчид	Шалгаруулалтын үзүүлэлт (хангасан/хангалтгүй гэж дүгнэх)		Мэргэжил, мэргэшил тэнцсэн байдал	Шалгаруулалтад тэнцсэн эсэх /Тийм, үгүй/	Байр эзлүүлсэн байдал
		Материал бүрдэлт	Тавигдсан шаардлага хангасан эсэх			
1	Н.Бямбадорж	Тийм	Тийм	Тийм	Тийм	3
2	А.Чулуунбат	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	6
3	Д.Алтангэрэл	Тийм	Тийм	Тийм	Тийм	1
4	Б.Ууганхүү	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	4
5	Ё.Байгалмаа	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	5
6	Я.Оюунсүрэн	Тийм	Тийм	Тийм	Тийм	2

НЭР ДЭВШҮҮЛЭХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Гишүүд:

 /Д.НЯМДЭЛГЭР/
 /Х.ГАН-ОЧИР/
 /Ц.ШИНЭХҮҮ/